

# Цргэний нийгмийн байгууллагын сайн жишээ

## Салбарын нөхцөл байдал

Өдөрт **1** бэлгийн хүчирхийлэл бүртгэгдэж шалгагдсан (Сүүлийн 3 жилийн ЦБ-ын гэмт хэргийн статистик мэдээ)

Бэлгийн хүчирхийлэл өртсөн **2** хүн тутмын **1** нь хүүхэд (ЦБ-ын гэмт хэргийн статистик мэдээ)



Хүчиндэх гэмт хэрэг жил бүр 30% орчмоор өсөж, насанд хүрээгүй хүүхдүүд хохирогч болох явдал нэмэгдэж байна (Бэлгийн хүчирхийлэл, хүчингийн гэмт хэрэг, UPR-Mongolia, 2019).



Хохирогчдын **80%** орчим нь 10-29 насны охид, залуу эмэгтэйчүүд

**46.8%** нь 8-17 насны охид

Насанд хүрээгүй хохирогчдын **87%** нь ЕБС-н сурагчид

Эх сурвалж: [http://www.upr-mongolia.mn/images/xupld/201910-Sexual\\_abuse\\_rape\\_UPR\\_mng.pdf](http://www.upr-mongolia.mn/images/xupld/201910-Sexual_abuse_rape_UPR_mng.pdf)

Охидын бэлгийн эрх чөлөөнд халдсан хүмүүсийн **78%** нь ойр гомтныхон. (ЦБ-ын гэмт хэргийн статистик мэдээ, 2019)

Эрүүгийн хуулийн нэмэлт өөрчлөлтийн уршгаар 14-16 насанд хүрээгүй хүнтэй бэлгийн харьцаанд орох гэмт хэрэг 2018 оны 10 сарын байдлаар өмнөх оноос **70%**-аар өссөн байна (Хүүхдийн бэлгийн халдлагыг байгалийн эсрэг гэмт хэрэг галтгаан, нөлөөлж буй хүчин зүйлс, судалгааны тайлан, 2019 он, ХСUC-ын Эргэн шинжилгээний хүрээлэн, ХТЭТ, МОНЭС).



## Хөөрхөн зүрх ТББ

Хөөрхөн зүрх ТББ нь 2012 онд хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийллийг таслан зогсоох зорилгоор нийгмийн ажилтан, сэтгэл судлаач эмэгтэйчүүдийн санаачлан байгуулсан иргэний нийгмийн байгууллага юм. Тэг бэлгийн хүчирхийлэл өртсөн хүүхдүүдэд нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэхээс гадна иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран бодлоготой нөлөөлөх, иргэдэд асуудлыг мэдээлэх, ойлгуулах, иргэдийн оролцоог нэмэгдүүлэхэд чиглэсэн нөлөөллийн үйл ажиллагаануудыг зохион байгуулсаар иржээ. Бэлгийн хүчирхийлэл нь бие, сэтгэл зүйн эрүүл мэндэд хамгийн гүн нөлөөтэй байдаг учраас тэд хүний эрхэд суурилсан, хохирогч төвтэй, хохирогчдог ээлтэй үйлчилгээ үзүүлэхийн сацуу ёс зүйг хатуу баримтлан ажилладаг юм.



Хөөрхөн зүрх ТББ нь 32 гишүүн, 40 сайн дурын гишүүд, ажлын албаны 10 гишүүнтэйгээр үйл ажиллагаа явуулж байна. Байгууллагын хүний нөөцийн гол цөм болсон сайн дурын гишүүдээ олон талт шалгуураар сонгон шалгаруулж, хүчирхийлэл өртсөн хүүхдүүдтэй хэрхэн харьцах, хүн төвт үйлчилгээний зарчмуудын талаар сургаж ажилладаг ажээ. Тэд хамтдаа 6 удаагийн үндэсний хэмжээний компанит ажил хөдөлгөөн зохион байгуулж, зарим нь жил тутам явагддаг болжээ.

## Хөөрхөн зүрх ТББ нь үндсэн дөрвөн үйл ажиллагааны чиглэлтэй.

### I. Бодлоготой нөлөөлөх

Жендэрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх болон хохирогч, гаван туулагчдыг хамгаалах, хүний эрхэд суурилсан хууль эрх зүйн тогтолцоог бий болгох зорилгоор бодлоготой нөлөөлөх үйл ажиллагаа явуулдаг. Энэ хүрээнд 2016 оны Эрүүгийн хуулийн нэмэлт өөрчлөлтөөр бэлгийн гарамтгыг гэмт хэрэгт тооцоггүй болж, хүчирхийллийн яллагдагчдын ял завших байдал үүссэн. Үүний эсрэг тэд иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран Эрүүгийн хууль болон Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулж чадсан байна.



### II. Урьдчилан сэргийлэх

Хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийллийг бууруулах зорилгоор хүчирхийлэл үйлдэхээс өмнөх, үйлдсэний гараа таслан зогсоох, дахин үйлдэхгүй байх гэсэн гурван түвшинд урьдчилан сэргийлэх олон талын үйл ажиллагаа зохион байгуулдаг. Урьдгийн ойлголтыг нэмэгдүүлэх, хохирогч болсон тохиолдолд хаана, хэнд хандах, эрхээ хэрхэн хамгаалуулах талаар мэддэг болсноор энэ төрлийн гэмт хэргийн гаралт буурдаг. Энэ хүрээнд олон төрлийн нөлөөллийн үйл ажиллагаа зохион байгуулааг байна.



### III. Мэргэжилтнүүдийн чадавх бэхжүүлэх

2012 оноос хойш олон улсын эрдэмтэн, мэргэжилтнүүдтэй хамтран жендэрт суурилсан хүчирхийллийн хохирогчдог үйлчилгээ үзүүлэгч төрийн болон төрийн бус байгууллагын мэргэжилтнүүдийн мэргэжлийн үр чадвар, мэдлэг туршлагыг нэмэгдүүлж, чадавхыг бэхжүүлсээр иржээ. Тухайлбал, сэтгэл заслын үйлчилгээ үзүүлэх, мэргэжлийн ёс зүй, бэлгийн хүчирхийлэл өртсөн хүүхэдтэй хэрхэн ажиллах, ураг төрлийн болон бэлгийн хүчирхийллийн гаван туулагчдог үйлчлэх зэрэг сэдвийн хүрээнд сургуулиудыг зохион байгуулж байна. Салбар бүрийн 5000 гаруй мэргэжилтнүүдгээр сургалтанд хамрагдааг байна.



### IV. Нийгэм-сэтгэлзүйн үйлчилгээ

Энэхүү үйлчилгээ нь бэлгийн хүчирхийллийн гаван туулагч хүүхдүүд болон тэдний гэр бүл нийгэм-сэтгэлзүйн нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэх замаар тэднийг хүчирхэгжүүлэх зорилготой. Хохирогч хүүхдүүдийн талаарх мэдээлэл ирсэн цагаас эхлэн үйлчилгээг хаах хүртэлх хугацаанд тухайн үйлчлүүлэгчид эрүүл мэндийн, боловсролын, хууль эрх зүйн гэх мэт бүхий л асуудалд холбоон зуулчлах, дэмжлэг үзүүлэх үйлчилгээ үзүүлэн ажилладаг. Мөн шаардлагатай тохиолдолд эрүүгийн хэргийн хэрэг бүртгэлт, мөргөн байцаах, прокурор, шүүхийн шатанд хууль ёсны итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр ажилладаг байна. Нийгмийн ажлын 2000 гаруй цаг, Сэтгэл зүйн үйлчилгээний 1500 гаруй цагийн үйлчилгээг 100 бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхдүүдэд үзүүлсэн.





# Хөөрхөн зүрх ТББ-ын онцлох гурван үйл ажиллагаа



## 1. Бэлгийн хүчирхийллээс үүдэлтэй сэтгэцийн гэмтэлд суурилсан нийгэм-сэтгэлзүйн үйлчилгээ

Өнгөрсөн 8 жилийн туршид Хөөрхөн зүрх ТББ бэлгийн хүчирхийллийн хохирогч болсон нийтгээ 100 гаруй хүүхдэд болон тэдний гэр бүлд нийгэм-сэтгэлзүйн нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлжээ. Эдгээр хүүхдүүд өөртөө итгэх итгэл сул болсон байдаг бөгөөд хохирогчдог ээлтэй энэхүү үйлчилгээгээрээ дамжуулан хүүхдүүдэд аймшигт дурсамжаас нь өөрсдөө гарах, илаарьшуулах, тухайн дурсамж сэргээх үедээ сэтгэл зүйгээ эрүүлээр таньж ирээдүйн амьдралдаа итгэлтэй болоход нь чиглэсэн олон төрлийн үйлчилгээ үзүүлж байна. Тоон үзүүлэлтээр авч үзвэл нийгмийн ажлын 351 клиник цагийн, сэтгэл зүйн 270 клиник цагийн үйлчилгээг үзүүлжээ.

Бэлгийн хүчирхийллийн гаван туулагч хүүхэд нь гэм эмггүйгээр насанд хүрэгчийн золиос болж амьдралынх нь үлдсэн хугацаанд тэрхүү аймшигт дурсамж, мэдрэмж арилахааргүй тогтсон байдаг.

Тухайн үеийн мэдрэмж үе үе сэргээгдэг бөгөөд үүнээсүүдэн буруу шийдвэр гаргах, амьдралдаа харамсах зүйлд ч ордог байна. Хөөрхөн зүрхчүүд хүүхдүүдэд эргээр үеийг гаван туулахад өөрийгөө хэрхэн удирдахад нь сурган чиглүүлж байна.

Тэд байгууллагынхаа ажилтан, сайн дурын ажилчдаа гаван туулагч хүүхдүүдийн онцлог, эмзэг байглын талаар тогтмол сургалт явуулж, хохирогчид ээлтэй үйлчилгээний соёлыг бий болгохоор чармайн ажилладаг. Илаарьшихад урт хугацаа шаардлагатай тул нийгэм-сэтгэлзүйн үйлчилгээг гаван туулагч хүүхдүүдийнхээ хүссэн цагт өгч байна. Өнгөрсөн жил 34 хүүхэд жилийн турш уг үйлчилгээг

## 2. Урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа: Хүчирхэг охид, хүчирхэг улс.


"Хүчирхэг охид, хүчирхэг улс" хөтөлбөр нь хүний эрх, жендэрийн тэгш байглын мэдрэмж сул нэгэн яамны төрийн нарийн бичгийн даргын харуу үйлдлээс эхтэй аж. 2013 онд Гүнж төвтэй хамтран охидын эрхийн олон улсын өдрийн хүрээнд охидын эрх хаана зөрчигдөж байгаа талаар ил захидлын аян зохион байгуулж, ирсэн 1500 захидлыг нэгтгэн холбогдох яам, газруудад уламжилахад тэр дарга "Охид ариун бол төр ариун гэж ярьдаг. Та нар юу гэж бодож байна?" гэж асууснаас үүдсэн байна.

Дараа жилээс хэлсэн үгийг нь эсрэгээр хөтөлбөрөө нэрлэн зохион байгуулж эхэлсэн бөгөөд 2017 онд Freda олон улсын залуу феминист эмэгтэйчүүдийн сангаас 5000 ам.долларын грант авч, 4 насны ангилал (3-10, 11-14, 15-18, 18+) бүхий сонгоон дээр суурилсан "Хүчирхэг охид" нэртэй гар утасны аппликэйшнийг бүтээсэн.

Уг апп нь хүүхэд, өсвөр насныхан, залуу

эмэгтэйчүүдийн эсрэг үйлдэгдэж буй бүхий л төрлийн бэлгийн халдлага, гарамт, хүчирхийллийг таних, түүнээс урьдчилан сэргийлэх мэдлэг, ойлголт өгч хүчирхэгжүүлэхэд зорилготой. Одоогоор 5000 гаруй таталттай байгаа бөгөөд хүртээмжийг нэмэгдүүлж казак хэл дээр гаргах, сонжоог улам бүр сайжруулах зэрэг хөгжүүлэлтийн ажлууд хийгдэж байна. Мөн энэ нь олон улсын сайн туршлага болж, англи хэл дээр гаргах талаар яригдаж байгаа ажээ.

Энэхүү аппликэйшний мэдээлэлд гүн шинжилгээ хийж, үр гүнд суурилсан сургалтыг 21 аймагт хийжээ. Нийт 15000 гаруй хүүхэд, залуучуудад уг сургалтыг шинэлэг, сонирхолтой аргаар зааж, хүний эрх, жендэрийн тэгш байдал, бэлгийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх мэдлэгийг олгоод байна.



## 3. Нэг тэрбумаараа тэмцье - One billion rising



ONE BILLION RISING буюу НЭГ ТЭРБУМААРАА ТЭМЦЬЕ арга хэмжээ нь V-day хэмээх охид, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг таслан зогсоох зорилготойгоор 2013 оноос эхлэн жил бүр өрнүүлж буй дэлхийн хэмжээний томоохон хөдөлгөөн юм. Энэхүү үйл ажиллагаагаар дамжуулан НЭГ ТЭРБУМ охид, эмэгтэйчүүд болон тэднийг хайрладаг, гэмжээг хүмүүс хүчирхийллийг таслан зогсоохын төлөө ЭСЭРГҮҮЦЛЭЭ УРЛАГААР ДАМЖУУЛАН ТЭМЦЭХ, ШААРДАХЫГ уриалдгаараа онцлогтой юм. Жил бүр Монголын эмэгтэйчүүдийн сангийн гэмжлэгтэйгээр зохион байгуулдаг уг олон улсын арга хэмжээнд Өнгөрсөн 7 жилд нийт 35,000 гаруй оюутан залуус, олон нийт болон хүний эрхийн тэмцэгчдийг үндэсний хэмжээнд (нийслэл, 21

аймаг) уриалан оролцсон байна. Уг хөдөлгөөнийг жилд гунджаар 30-40 иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран зохион байгуулдаг бөгөөд Хөөрхөн зүрх ТББ манлайлан ажилласаар ирсэн. Жил ирэх тусам уг хөдөлгөөнд оролцогчдын тоо нэмэгдэж, олон нийт, тэр гундаа залуучуудын гунд танигдсан жил тутмын тогтмол арга хэмжээ болон өргөжжээ. Сүүлийн жилүүдэд жендэрт суурилсан, хүүхдийн эсрэг хүчирхийллийн тохиолдлууд олон нийтийн анхаарал оруулж, эсэргүүцлээ илэрхийлэн зохион байгуулдаг энэ чиглэлийн жагсаал цуглаан нэмэгдсэн нь энэ хөдөлгөөний шууд бус нөлөө билээ.